



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/374

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2, "Спортын аварга" дэд хөтөлбөрийн 4.2.6, 6.6 дахь (4.2.6. Үндэсний спортын төрөл, 6.6. Энэхүү хөтөлбөрийн санхүүжилтээс Ховд аймгийн харьяат, орон нутгаас олимп, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнд орох эрхээ авсан болон бэлтгэл сургуулилтад гарсан тамирчид, дасгалжуулагчдад мэргэжлийн байгууллагын (Биеийн тамир, спортын газар) саналыг (тойрох зурах) үндэслэн дэмжлэг үзүүлнэ) заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Ардын хувьсгалын 100, 101, аймаг багуулагдсаны 90, 91 жилийн ойг угтан Улаанбаатар хотод бэлтгэл сургуулилт хийж байгаа Ховд бөхийн дэвжээний бөхчүүдэд 30,000,000 төгрөгийн дэмжлэгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 30,000,000 төгрөг (гучин сая)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.3 дахь Спортын салбарын дэд хөтөлбөрүүд ("Спортын аварга") хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1378



Аймгийн Засал даргын 2023 оны
 06 дугаар сарын 05-ны өдрийн
 А/374 дүгээр захирагчийн
 хавсралт

**ХОВД БӨХИЙН ДЭВЖЭЭНИЙ БӨХЧҮҮДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
 ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Хамрагдах бөхчүүд	Бөхийн дэвжээний нэр	Төсөв (төгрөг)
1	Ховд бөхийн дэвжээний Улаанбаатар хотод бэлтгэл хийх бөхчүүдэд	Ховд бөхийн дэвжээ	30,000,000
Дүн			30,000,000

-oOo-